



ХӨХӨӨ НАМЖИЛААС МОРИН ХУУР ҮҮСЭЛТЭЙ ЮУ?

᠗Б.Өсөхбаяр

᠗МУБИС-Багшийн сургууль, багш

Холбоо барих зохиогч: usukhbayar@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Монголын ард түмний арга билгийн шүтэн барилдлагын гүн сэтгэлгээ, ардын домог, утга соёл, дуу хөгжим, ёс заншил, бэлгэдэл хүндэтгэлийн нэгдмэл цогц болсон Морин хуур хөгжмийн талаар судлахад түүний үүсэлтэй холбоотой домог заавал судлагдана.

Энэхүү судалгааг хийхдээ түүхэн үечлэл монголчуудын түүхийн эх сурвалжуудыг эх материалаа болгосон бөгөөд судалгаа хийх явцад гадны улс оронд хийгдсэн зарим судалгааг харьцуулан судлав. Цаашид бид морин хуураа судлахдаа дан ганц морин хуур хөгжим бус нуст чавхдаст хөгжимтэй харьцуулж судлах нь хөгжим судлалын хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийн нэг гэж үзэх боломжтой.

Түлхүүр үг

Намжил, Морин хуур, Аргусан, Гудок

Удиртгал

Монголын ард түмний дунд ам амнаас дамжин ирсэн “Хөхөө Намжил” хэмээх домгийн гол дүр Намжил хэмээх залуу Алтай нутагт харуулын алба хаах үест тэр нутгийн баян айлын охинтой сэтгэл дасаж харуулын албанаас чөлөөлөгдөн төрсөн нутагтаа буцахад нь хайртай бүсгүй нь адуун сүрэг дундаасаа

“Сарын газрыг өдрөөр товчилдог

Өдрийн газрыг цагаар товчилдог” хурдан сайхан хүлэг морь бэлэглэж түүгээрээ Намжил наран ургахтай зэрэгцэн давхихад нар ургахтай зэрэгцэн Алтай нутагт хайрт хүүхэн дээрээ очдог байв. Нэгэн өдөр говь нутгаасаа гараад явж байтал аян замд хурдан хүлэг нь эндэж түүнийгээ дурсан санахын эрхэнд морин хуур хийж морин хуур хөгжим үүссэн гэж үздэг. Гэвч энэ үнэн үү?

Үндсэн хэсэг гарчиг 1 Хөхөө намжилын талаар

“Хөхөө Намжил гэдэг хүн болбол одоогийн Өмнөговь аймгийн Балдан засгийн хошуу өнөөгийн Хүрмэн суманд төрж гэж үзэж байна”...(Бадраа, 2005, х.19) Сайн

ноён хан аймгийн Балдан засгийн хошуу буюу одоогоор Өмнөговь аймгийн Хүрмэн сумын амьдарч байсан хүн аж. “Хөхөө Намжилын тухай одоо ярья. Хөхөө Намжил XIX зууны дундуур нутагтаа Алтай нутгаас цэргийн харуулын алба хаагаад тэнд явж”... (Бадраа, 2005, х.20)

“1956 онд Өмнөговь аймгийн наадамд би очсон. Тэндхийн кино механикч Дэмчиг гэж байгаа юм. Тэр Дэмчигийн эгч нь хэлж байгаа юм. Намайг жаахан байхад ижий, аав хоёр ярьж байгаа юм. Хөхөө намжил биднийг жаахан байхад ядуураад ирсэн юм гэж тэр авгай надад хэлж байгаа юм. Тэгээд “Үнэн үү?” гэхээр үнэн байлгүй яхав.”

Ж.Б: 56 онд хэдий настай хүн байсан юм?

Ж.Д: 56 онд нэг наяд насны байсан. Дэмчиг одоо бий л дээ”... (Бадраа, 2005, х.20) Үүнээс үзэхэд Хөхөө Намжил бодит хүн, цаашлаад хэзээ амьдарч байсан нь ч ойлгомжтой болж байна.

Хөхөө Намжилыг үлгэр, домог биш бодит хүн байсан эсэх нэгэн баримт байгаа нь “Харин домгийн эзэн Хөхөө намжил гэдэг бодот хүн Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Хөвсгөл, аймгуудад байсан тухай аман мэдээ, хууч яриа байдаг боловч сүүлийн үеийн эрдэмтэн судлаачдын эрэл хайгуул аман мэдээг нилээд баталгаажуулж байна.”(Энэбиш, 2017, х.108) Хөхөө намжилын үр удам хангай нутагт амьдарцгаадаг, “Хөхөөнийхэн хэмээх ургийн овогтой гэдгийг нь тогтоогоод байгаа аж.

Улсын алдарт гавьяат жүжигчин, XX зууны манлай, их дууч Ж. Дорждагва нь “Хөхөө Намжил нь хуур хийсэн байх. Гэхдээ хуур тэр үест үүсээгүй нь лав...”(Бадраа, 2005, х.21) гэжээ. Морин хуурыг хэрвээ Намжилаас үүсэлтэй гэж үзвэл 250 орчим жилийн настай л хөгжим байхаар.

Ж. Дорждагва нь цааш өгүүлэхдээ Хөхөө намжил тэр алтан тогос бор морио үхэхлээр шир, сүүлээр нь морин хуур хийгээд “Жонон” татлага татсан гэдэг тэр нь үнэн юм байлгүй. Балдан засгийнхан бол жононгоо онц сайн дарна шүү дээ...” гэснээс үзэхэд морин хуур хийсэн байж болох.


Намжилын “Хөхөө” гэдэг нэрний учир нь их сайхан дуулдаг мөн цээл буюу нарийн хоолойтой байсан учир ийн нэрийдсэн байна. Мөн Намжил нь “Ар хөвч” хэмээх ургын дууг зохиосон нь үнэн гэдгийг Их дууч маань бүх талаас нь тайлбарлан нутаг ус, ахмад буурлуудаасаа тэмдэглэн авч үлдсэн нь нэн чухал баримт болж байна.

Хөхөө намжилын домог хэмээх хуурын үлгэрт татлагыг 1957 оны МЗО-ны анхдугаар наадамд МУАЖ Н. Дагийранз нь “Дэлгэцэнд мөнхөрсөн талын хуурч” нэвтрүүлэгт дурдсан байна.

Үндсэн хэсэг гарчиг 2 Морин хуурын үүслийг эрэлхийлэх нь

Хүрэн халзан хуур XVII зууны дунд үеийн хөгжим 2014 онд Сорен Винема гэдэг дэлхийналдартай хөгжимчин “Хүрэн халзан” хуурыг худалдан авсан. Тэрбээр эртний хөгжим цуглуулдаг. Маш олон цуглуулгатай, хөгжмийн дэлгүүртэй байсан. Мөн тэр хүн энэ хуурд маш их хайртай байсан гэдэг. Тэр үед анх манай шавь хуурын талаар олж мэдээд авах гэж хэд хэдэн удаа гуйсан ч өгөөгүй. Түүнээс хойш долоон жилийн дараа 2021 онд Сорен Винема нас барсан. Ингээд үр хүүхдүүд нь өвлөн уламжлагч болсон. Ингээд хуурыг дуудлага худалдаанд зарах гэсэн боловч хүн аваагүй учир анх худалдан авсан угсаатны хөгжим судлаач дээр очиж “Та энэ хөгжмийн зэмсгийн

учрыг олоод өгөөч” гэсэн байдаг. Тэгээд судлаач дахин дуудлага худалдаа зохион байгуулж яг зарах гэж байхад нь манай шавь зургийн авч над руу явуулсан юм. Би угсаатны хөгжим судлаач Христиан Хаслунд, Потанин, Н.А.Чарусин, зэрэг судлаачдын XVII зууны зургуудтай харьцуулж харсан. Бас энэ морин хуурын ерөнхий байдлын талаар багагүй мэддэг байсан учраас энэ хуурыг хараад шууд таньсан.



ОХУ-ын археологийн багийнхан Новгород хотын ойролцоогоос XI зууны үеийн Гудок гэх нэртэй нумт, чавхдаст хөгжим олдсон бөгөөд хойд хөрш маань морин хуурын төст хөгжим мөн хэмээн таамаглажээ. Таамаг нь үнэн ч байж болохыг Нум болон царны хэлбэр мөн хөглөгөөтэй нь холбон тайлбарлажээ.

Судалгааны үр дүн

Морин хуурын үүслийн талаар хэд хэдэн түүх байдаг бөгөөд хамгийн зөв байж болох үнэн байж болох баттай эх сурвалжуудаас харьцуулан судалж үзэхэд хэд хэдэн үр дүн харагдаж байна.

Хөхөө намжилын домогтой морин хуурын гарлыг холбоход 270 орчим жилийн настай хөгжим байхаар боловч Хүрэн халзан хуурын судалгаанаас үзэхэд даруй 420 орчим жилийн настай болж цаашилж байна. Гэвч бидний сайн мэдэх алтан товч дээр аргусан хуурч гэж гарч буйгаас үзэхэд үүсэл нь дахин цаашилж XII-XIII зуундүүсэн мэт түүхийн тавцан дээр гарч ирлээ.

Мөн ОХУ-ын археологийн малтлагаас гарч ирсэн гудок хөгжмөөс үзэхэд дахин 200 жилээр үүсэл цаашилж харагдлаа. Иймээс бид судалгааг хийхдээ эцэг өвгөдөөс уламжлагдан ирсэн аман болон бичгийн сурвалжаас гадна гадны ном товхимол сөхөн харах нь судалгааг илүү бодит үнэн байх боломжтой юм байна гэдэг үр дүнгээс харагдаж байна.



Дүгнэлт

Үндсэн гарчиг 1.1 Хөхөө намжилын домог нь морин хуурын үүсэлтэй холбоогүй нь дараах зүйлүүдээр батлагдлаа.

Үндсэн гарчиг 1.2 Хөхөө намжил нь бодит хүн бөгөөд XVIII зууны дунд үед төрсөн гэж таамагладаг бөгөөд одоо ч тэр хүний үр удам амьдардаг талаар дурдсан. Үүнийг цааш нь лавшруулан судлана.

Үндсэн гарчиг 2.1 Хүрэн халзан хуур нь XVII зууны дунд үест хамаарах нь судалгаагаар нотлогдож байна. Гэхдээ үүгээр зогсохгүй цаашид Хүрэн халзан хуурын мод болон ширнээс эдийн шинжилгээ авч цаг хугацааг илүү нарийн тогтоохоор ажиллаж байгаа бөгөөд хугацаа нь бүр цаашилж ч магадгүй гэж Д. Ганпүрэв судлаач маань ярилцлагадаа дурдсан.

Үндсэн гарчиг 2.2 Гудок хөгжмийг оросын судалгааны баг Азиас тэр одоогийн монгол үндэстнээс гаралтайг хэд хэдэн зүйлээр нотлон гаргаж иржээ.

1-д Хэлбэр бөгөөд шанаган хуур, бийбаа хөгжмийн хэлбэртэй адилаас гадна Хийц бүтээцийн хувьд иш нь болон нум нь морин хуурын тэр дундаа икэл хөгжмийн иш болон нумтай адил.

2-т Хөг дуурьсал Бага наймцын Ре(d), Соль(g), 1-р наймцын Ре(c¹) зэрэг эгшгүүдээр хөглөсөн хуучин үеийн морин хуурчдын бичлэгээс сонсоход ихэнх хуурын хөг нь бага наймцын Ре(d), Соль(g) эсвэл Бага наймцын До(c), Фа(f) байсан)-ын хөгтэй ойролцоо байлаа.

Морин хуур хөгжим маань адуу гаршуулан уналга, эдэлгээнд ашиглаж ирсэн үетэй холбогдох талаар зарим эх сурвалжид бичсэн байдаг учир үүнийг үргэлжлүүлэн судлууштай.

Талархал

Энэхүү өгүүллийг шүүн тунгааж, хэвлэхэд ихээхэн туслалцаа үзүүлсэн “Оюуны хөтөч” сэтгүүлийн хамт олонд баярласан талархсанаа илэрхийлье. Номын цагаан буян үргэлж та бүхнийг ивээж байх болтугай.

Ном зүй

Бадраа, Ж. (1998) Монгол ардын хөгжим. УБ хот: T&U printing Co.Ltd

Гэгээрлийн яамны хэвлэл. (1961) Аргусан хуурчийн домог. Улаанбаатар: 18-23-р талд

Жанцанноров, Н. (2005) Их дуучны яриа. Улаанбаатар: ADMON printing, publishing&more 19-28-р талд

Чоймаа, Ш. (2011) Монголын нууц товчоо. Улаанбаатар: “Мөнхийн үсэг” хэвлэлийн газар

Энэбиш, Ж. (2012) Монголын хөгжим судлалын дээж бичиг. Улаанбаатар: Soyombo printing Co.Ltd

Энэбиш, Ж. (2017) Монголын хөгжмийн их нүүдэл I. Улаанбаатар : ADMON printing, publishing&more 106-108-р талд

<http://ru.wikipedia.org/wiki/>

<https://www.facebook.com/watch/?v=2492003077605948>


<https://youtu.be/RxYfL8MLvjI>

<https://youtu.be/gEBiIQiCro>

DID THE FIDDLE COME FROM THE CUCKOO NAMJIL?

^aUsukhbayar B.

^aTeachers School, MNUE

Corresponding author: usukhbayar@msue.edu.mn 

Abstract

When studying about Morin fiddle music, which is a unified complex of the Mongolian people's deep thinking, folk legends, meaning, culture, music, customs, and symbols, the legends related to its origin must be studied.

In conducting this research, historical periodicals were used as the source material of Mongolian history, and during the research, some studies conducted in foreign countries were compared. In the future, when we study the cello, we can consider it as one of the factors affecting the development of musicology.

Keywords

Cuckoo namjil, Morin khuur, Argusan, Gudok